



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 01 өдөр

Дугаар А/28

Бат-Өлзий сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэг, Сангийн сайдын “Журам батлах тухай” 2021 оны 06 дугаар сарын 30-ний өдрийн 103 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжих Бүрэгтий багийн төвийг өндөр хүчдэлд холбох ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Н.Орхонтуул (Засаг даргын орлогч)

Гишүүд: Б.Сангицэрэн (Нягтлан бодогч)

Ж.Ганчулуун (Иргэний төлөөлөл)

Б.Болормаа (Иргэний төлөөлөл)

Нарийн бичгийн дарга: Б.Орбиш (Нийгмийн ажилтан)

2. Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулан, мэдэгдэл, гэрээний төслийг өргөн мэдүүлэхийг Үнэлгээний хороо (Н.Орхонтуул)-д даалгасугай.

3. Тендер шалгаруулалттай холбоотой баримт бичгийг хууль тогтоомжийн дагуу архивын нэгж бүрдүүлж, Архив, бичиг хэргийн эрхлэгчид хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Б.Орбиш)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН

